

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

## Агуулга

1.	Аудитын гэрчилгээ.....	3
2.	Аудитын тайлан .....	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3.	Менежментийн захидал .....	10
3.1	Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал .....	
3.2	Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал.....	11
3.3	Цалингийн данстай холбоотой асуудал .....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	12
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4	Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/Өмчийн өөрчлөлтийн тайлан .....	19
4.5	Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	20
4.6	Аудит хийсэн Нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан .....	22
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	23



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ХАРЬЯА ҮНДЭСНИЙ АВРАХ  
БРИГАДЫН ЗАХИРАГЧ, ХУРАНДАА  
Д.НАМСРАЙ ТАНАА

2020.02.21 № 06/585  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал


- Ажиллагсдын орон сууцны ашиглалтын зардалд төсвөөс 40,122.9 мянган төгрөг зарцуулсан;
- Шатахууны урамшуулалд олгосон 6,430.0 мянган төгрөгийн талоныг бүртгэж тайлагнаагүй;
- Байгууллагын ажилтнуудад 2019 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг олгохдоо үндсэн цалингийн 60.0 хувиар тооцож, 40,606.8 мянган төгрөгийг илүү олгосон.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудитын тайлан

### 2.1 Оршил

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Үндэсний аврах бригадын захирагч, хурандаа Д.Намсрай Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн ашиглах боломжгүй үндсэн хөрөнгөнд элэгдэл байгуулахгүй байх, төсвийг зориулалтын дагуу зарцуулах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 03-наас 2 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Мөнхчимэг, Ч.Дашдаваа, гэрээт аудитор Ш.Ичинхорлоо нар хариуцаж хэрэгжүүлэв.

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



## **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригад Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах, нэрвэгдэгсдэд яаралтай тусламж үзүүлэх, аюулгүй газарт зөөвөрлөн гаргах, эд хөрөнгийг авран хамгаалах гэж эрхэм зорилго тодорхойлон ажиллажээ.

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх;
- Эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах;
- Гамшиг нэрвэгдэгсдэд яаралтай тусламж үзүүлэх.

Үндэсний аврах бригадын үндсэн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд дээрх бодлого, хууль, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригад нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “ACOLOUS 3.0” программ хангамж ашигладаг байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 14 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан.

## **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны гурав дугаар

улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар сонгож 69,124.8 мянган төгрөгөөр тооцсон.

## 2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,268,767.7 мянган төгрөгөөр буюу 38.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,749.3		-4,749.3
Авлага	832.8	5,827.8	4,995.0
Бараа материал	1,563,554.6	1,936,404.8	372,850.2
Үндсэн хөрөнгө	9,440,470.5	13,336,142.3	3,895,671.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>11,009,607.2</b>	<b>15,278,374.9</b>	<b>4,268,767.7</b>
Өр төлбөр	0.0	15,102.4	15,102.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	11,009,607.2	15,263,272.5	4,523,665.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>11,009,607.2</b>	<b>15,278,374.9</b>	<b>4,268,767.7</b>

Авлага дансны үлдэгдэл 4,995.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд цалин илүү тооцож олгосноос 5,827.8 мянган төгрөгийн авлага үүссэн. Оны эхний үлдэгдэл 832.8 мянган төгрөгийн авлагыг бүрэн барагдуулсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 372,850.2 мянган төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай. Үүнд:

- Бараа материалын дансанд төсвөөс 457,627.0 мянган төгрөгөөр түлш шатах тослох материал, хүнсний материал, сэлбэг хэрэгсэл зэрэг материалууд худалдан авсан.
- Онцгой байдлын ерөнхий газар болон улсын нөөцийн салбаруудын балансаас 526,522.1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй шилжүүлэн авсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,895,671.8 мянган төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай. Үүнд:

- Онцгой байдлын ерөнхий газраас Үндэсний аврах бригадад балансаас баланст 1,338,532.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авсан.
- Төсвөөс 31,767.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан.
- Газрын эзэмших эрхийг 3,441,750.6 мянган төгрөгөөр дахин үнэлж бүртгэлд тусгасан.

Өр төлбөр дансны үлдэгдэл 15,102.4 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын 12,877.9 мянган төгрөгийн, цалингийн 2,224.5 мянган төгрөгийн өглөгийг тус тус барагдуулаагүйгээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 15,263,272.5 мянган төгрөг болж 4,253,665.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 4,253,665.3 мянган төгрөг гарсантай холбоотой.



## 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөр арга хэмжээнд зориулан 5,639,823.2 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Тайлант онд 5,478,601.5 мянган төгрөгийг зарцуулж, 161,221.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн ба гүйцэтгэл 97.1 хувьтай байгаа нь:

- Цалин хөлс, нэмэгдэл урамшил зардлыг 78,979.1 мянган төгрөгөөр хэмнэсэн нь батлагдсан орон тооноос 25 хүнээр дутуу ажилласан ба орон тоо бүтэц зохион байгуулалтаа зөв төлөвлөөгүйтэй холбоотой.
- Түлш халаалтын зардлыг 30,102.3 мянган төгрөгөөр хэмнэсэн нь 2019 онд Үндэсний аврах бригад дулааны нэгдсэн шугамд холбогдсон ба Налайх дүүрэгт байрлах Уул уурхайн аврах анги ашиглалтын талбайгаа багасгасантай холбоотой.
- Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардлыг 2,433.9 мянган төгрөгөөр хэмнэсэн нь 2019 оноос Үндэсний аудитын газар санхүүгийн тайлангийн аудит хийж байгаатай холбоотой.
- Хоол, хүнсний зардлыг 41,241.4 мянган төгрөгөөр хэмнэсэн нь хоол хүнсний зардлаа бодит тооцоо судалгаанд үндэслэн зөв төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:** Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого буюу Ган татлага шалгах лабораторийн үйл ажиллагааны орлогод 28,950.0 мянган төгрөг, Онцгой байдлын ерөнхий газраас 228,435.5 мянган төгрөг, нийт 257,385.5 мянган төгрөгийг бүрдүүлж, 256,034.0 мянган төгрөг зарцуулж, 1,351.5 мянган төгрөг төсөвт төвлөрүүлсэн байна.

### 2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 4,986,735.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 4,875,246.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 46,552.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 64,936.7 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө. Үүнд:

- Өмнөх онд дахин үнэлгээгээр байгууллагын эзэмшилд байгаа газрыг үнэлэхдээ хэмжих нэгжийг андуурч тооцоолсноос газар эмших эрх болон, засгийн газрын капитал дансыг 3,441,750.7 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг тайлант залруулахдаа үнэ төлбөргүй хүлээн асан орлогоор бүртгэсэн;
- Бараа материалын дансанд 985,956.6 мянган төгрөгийн бараа материалын дансны ангиллыг буруу бүртгэсэн;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд 443,179.3 мянган төгрөгийн зардлуудыг зөрүүтэй илэрхийлсэн;
- Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлийг зардлын төсвөөс 4,000.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө, мэдээлэл технологийн үйлчилгээний зардлаас 199.5 мянган төгрөгийн багаж хэрэгсэл, цэвэр бохир усны зардлаас 160.0 мянган төгрөгийн тоолуур зэргийг бэлтгэж, аж ахуйн материалаар зардалд буруу бүртгэсэн.

Ажиллагсдын орон сууцны ашиглалтын зардалд төсвөөс зарцуулсан 40,122.9 мянган төгрөгийг оршин суугчдаас авах авлагын тооцоо үүсгэн бүртгэж тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөх

Шатахууны урамшуулалд олгосон 6,430.0 мянган төгрөгийн шатахууны талоныг бүртгэж тайлагнаагүй нь Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.3.4."төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 14 дүгээр зүйлийн 14.4.5 “Бүх орлого” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 64,936.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

## **2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Үндэсний аврах бригадын ажиллагсдын 44 айлын орон сууцны ашиглалтын болон засвар үйлчилгээ, цэвэрлэгээ, бохир усны тээвэрлэлтийн зардлын зарцуулалт, бүртгэл тайлагналын талаар бодлогын баримт бичигт тодорхой тусгаж өгөөгүйгээс дээрх зардлуудыг төсвөөс гаргаж, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулан, төсвийн үргүй зардал гаргаж байгааг төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12 Шилэн дансны мэдээлэл**

ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 93 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## **2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 61,928.4 мянган төгрөгийн зөрчил арилгах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Нийт 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### ***“Хязгаарлалттай” дүгнэлт***

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Нэмэлт төсвийн дансны кассаар 3,400.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", "Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар баталсан "Байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам" -ын 3.8 дахь "Мөнгөн кассын нярав нь анхан шатны орлого, зарлагын баримтыг үндэслэн мөнгөн кассын гүйлгээг хийнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Хөрөнгө шамшигдах, тайлан буруу илэрхийлэх.

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар баталсан "Байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам" -ыг мөрдөж ажиллах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **3.2 Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал**

### **3.2.1 Илрүүлэлт:**

Тайлант онд ажиллагсадтай холбоотой 5,827.6 мянган төгрөгийн авлага, 2,224.5 мянган төгрөгийн өглөг, 12,877.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг тус тус үүссэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

### **3.2.2 Эрсдэл:**

Хууль эрх зүйн акт, хууль журам зөрчигдөх.

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Ажиллагсадтай холбоотой тооцоог тухай бүр хийж, авлага, өглөгийг үүсгэхгүй байх.

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **3.3 Цалингийн данстай холбоотой асуудал**

### **3.3.1 Илрүүлэлт:**

Байгууллагын ажилтнуудад 2019 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг олгохдоо үндсэн цалингийн 60.0 хувиар тооцож, 40,606.8 мянган төгрөгийг илүү олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.2. "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй", 2 дугаар зүйлийн 2.3. "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

### **3.3.2 Эрсдэл:**

Батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулах, зориулалт бусаар зарцуулах.

### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын ажилтнуудад урамшууллыг олгохдоо Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.

### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,569,136,680.30</b>	<b>1,942,232,649.31</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>4,749,316.00</b>	<b>0</b>
<b>31100</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>4,749,316.00</b>	<b>0</b>
31110	Төгрөг	4,749,316.00	0
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>832,800.00</b>	<b>5,827,851.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>832,800.00</b>	<b>5,827,851.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	832,800.00	0
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0	5,827,851.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,563,554,564.30</b>	<b>1,936,404,798.31</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>73,301,992.40</b>	<b>1,182,972,584.48</b>
35110	Тусгай зориулалттай материал	68,177,796.38	1,178,804,265.82
35130	Эм боох материал	5,124,196.02	4,168,318.66
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0	190,017,053.25
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>1,486,907,571.90</b>	<b>555,025,160.58</b>
35410	Бичиг хэргийн материал	6,260,616.00	6,781,747.00
35420	Аж ахуйн материал	49,448,723.98	55,828,078.98
35430	Сэлбэг хэрэгсэл	116,439,496.00	149,846,048.92
35440	Түлш, шатах тослох материал	14,348,305.00	8,318,504.50
35450	Барилгын засварын материал	45,821,300.00	40,568,190.00
35460	Хүнсний материал	4,179,463.00	19,553,172.00
35470	Бусад хангамжийн материал	1,250,409,667.92	274,129,419.18
35600	Мал амьтад	3,345,000.00	8,390,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>9,440,470,555.86</b>	<b>13,336,142,263.92</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>9,440,470,555.86</b>	<b>13,336,142,263.92</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>9,405,599,981.07</b>	<b>9,859,576,047.09</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,776,759,610.00	8,181,822,190.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-88,478,538.76	-438,639,977.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,712,508,435.15	6,066,724,321.15
39204	Хуримтлагдсан элэгдэл	-4,756,130,823.83	-5,001,697,740.81
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,811,225,983.32	3,914,640,073.32
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,088,796,919.78	-3,245,304,316.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	186,268,436.65	187,633,616.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-150,714,149.64	-163,075,976.87
39209	Зам, гүүрийн байгууламж	2,496,000.00	2,496,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-2,496,000.00	-2,496,000.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0	354,515,910.00
39217	Ном	2,957,947.96	2,957,947.96
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>34,870,574.79</b>	<b>3,476,566,216.83</b>
39301	Програм хангамж	3,804,050.00	3,804,050.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,698,633.21	-3,753,633.17
39303	Бусад биет бус хөрөнгө	34,765,158.00	3,476,515,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>11,009,607,236.16</b>	<b>15,278,374,913.23</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>15,102,373.96</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>15,102,373.96</b>

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригадын 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0</b>	<b>15,102,373.96</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	15,102,373.96
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11,009,607,236.16</b>	<b>15,263,272,539.27</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>11,009,607,236.16</b>	<b>15,263,272,539.27</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,172,257,683.87	4,172,257,683.87
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>360,785,329.84</b>	<b>1,172,699,990.95</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,028,644,483.83	360,785,329.84
51220	Тайлант үеийн үр дүн	1,389,429,813.67	811,914,661.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,476,564,222.45	9,918,314,864.45
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>11,009,607,236.16</b>	<b>15,278,374,913.23</b>



## 4.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөг/	
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>6,414,196,337.52</b>	<b>7,721,285,893.49</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,214,205,779.52</b>	<b>1,824,077,193.49</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,214,205,779.52</b>	<b>1,824,077,193.49</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>2,214,205,779.52</b>	<b>0</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	38,686,556.91	0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,175,519,222.61	0
120009	Бусад орлого	0	16,733,624.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	1,288,380,271.90
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	518,963,297.59
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,199,990,558.00</b>	<b>5,897,208,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>3,947,725,900.00</b>	<b>5,639,823,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,947,725,900.00	5,639,823,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>252,264,658.00</b>	<b>257,385,500.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	243,996,960.00	228,435,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,267,698.00	28,950,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,971,841,869.79</b>	<b>6,912,481,232.38</b>
